



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар A/277

Арвайхээр

### Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "в", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан санал авах өдөр буюу 2021 оны 06 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундаа (18% хүртэлх спиртийн сүл агууламж бүхий) худалдаалах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахгүй байх, 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийн үйл ажиллагааг түр хориглосугай.

2. Аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон тухай шийдвэр хэвээр мөрдөгдөж байгааг дурдсугай.

3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг холбогдох мэдээллээр хангаж, нийтийн хэв журмыг сахиулан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



01110059